



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААНЫ СУРГУУЛЬ



ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

WORLD AFFAIRS

МОНГОЛ УЛСЫН
ИХ СУРГУУЛЬ
ОЛОН УЛСЫН
ХАРИЛЦАА

2006 №1 273 (12)



Улаанбаатар хот

Тус сэтгүүл нь анх 1996 оноос "Алтан аргамж" нэрээр, 2002 оноос "Олон улсын харилцаа" нэрээр гарч байна.

The journal has been published since 1996 as "Altan argamj" and since 2002 as "World Affairs"

Сэтгүүлийн зөвлөл:

Эрхлэгч:

Н.Алтанцэцэг (тэр.проф.доктор Ph.D)

Нарийн бичгийн дарга:

Д.Тунгалаг (проф.доктор Ph.D)

Гишүүд:

Ж.Баясах (тэр.проф.доктор Sc.D)
Ц.Гүрбадам (проф.доктор Sc.D)
Д.Цолмон (тэр.проф.доктор Ph.D)
Б.Хулдорж (проф.доктор Ph.D)
Д.Намсрай (дэд проф.доктор Ph.D)
Д.Отгончимэг (дэд проф.доктор Ph.D)
Б.Энхбаяр (проф.доктор Ph.D)
Ж.Баттогтох (доктор Ph.D)

Хэвлэлийн эх бэлтгэсэн:

С.Оюунсүрэн

Сэтгүүлийн хаяг:

МУИС-ийн Олон улсын
харилцааны сургууль
Шуудангийн салбар – 46 а, хайрцаг-6
Улаанбаатар, Монгол улс
Утас: 354610; 354611; 354618
Факс: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

Editorial Board:

Editor in Chief:

N.Altantsetseg (Prof.Ph.D)

Editor:

D.Tungalag (Prof.Ph.D)

Members:

J.Bayasakh (Prof. Sc.D)
Ts.Gurbadam (Prof. Sc.D)
D.Tsolmon (Prof.Ph.D)
B.Khuldorj (Prof.Ph.D)
D.Namsrai (Prof.Ph.D)
D.Otgonchimeg (Prof.Ph.D)
B.Ehkhbayar (Prof.Ph.D)
J.Battogtokh (Ph.D)

Assistant:

S.Oyunsuren

Editorial Address:

School of Foreign Service
National University of Mongolia
P.O. – 46 a, Box-6
Ulaanbaatar, Mongolia
Tel: 354610; 354611; 354618
Fax: (976-11)354610
E-mail: muis_sfs@yahoo.com

АГУУЛГА

I. Их Монгол улс, Эзэнт гүрний түүх, соёлын асуудал

Н. Алтанцэцэг

Чингис хааны үнэлгээний талаарх гадаадын (орос, өрнөд, хятад) судлаачдын судалгаа, үзэл баримтлал..... 5

Д. Цолмон

Дипломат ёс горим төрийн ёслолын уламжлал, шинэчлэлийн зарим асуудал 25

Ж. Баясах

Нүүдлийн хийгээд суурин соёл иргэншлийн ялгаа, харилцан хамаарлын асуудал 34

Ж. Баттөр

Солонгост Монголын арми анх орсон түүхийг тодруулах нь..... 44

Г.Баасанхүү

“Рах Mongolica” буюу Их Монгол улсын гадаад бодлогын “энхээр тохинуулах ” үзэл санааны тухай..... 54

С.Оюунсүрэн

Ойрхи Дорнодын талаар явуулсан Монголын гадаад бодлого (XIII-XIV зуун)..... 60

Д. Дашидулам

Хубилай хааны Азид явуулсан бодлого..... 72

Ч. Болдбаатар, Д. Мөнх-Очир

Их Монгол улс: “Жанжлалын тогтвортой байдал”-аас “хэт тэлэлт” рүү түүхэн үзэгдлийн судалгааны аргачлалын асуудалд..... 91

II. Олон улсын харилцаа

Удо Б. Баркманн

Орос, Хятад хоёрын дундах Монгол орон буюу Монгол улс өв уламжлалаа хадгалан хамгаалах зайлшгүй шаардлагатай болох нь..... 97

Ху Жун Кунь

Тайваний бүх ард түмний санал хураалтын үйл явц болон хэтийн төлөв..... 123

Таро Асо

Эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн нум: Япон улсын өргөжин хөгжиж буй дипломат үйл ажиллагааны хүрээ..... 136

Ясүёши Ичихаши

Японы гадаад бодлого ба Япон-Монголын харилцаа 145

III. Олон улсын эдийн засгийн харилцаа

Д. Тунгалаг

Олон улсын аялал жуулчлалын хэтийн төлөв ба Монгол улс 153

Д. Намсрай

Глобалчлал ба ажиллах хүчний гадаад шилжих хөдөлгөөн..... 161

Д. Начин

Монгол улсын гадаадын хөрөнгө оруулалтын стратегийг боловсронгуй болгох асуудалд..... 168

ЧИНГИС ХААНЫ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН (ОРОС, ӨРНӨД, ХЯТАД) СУДЛААЧДЫН СУДАЛГАА, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Н.Алтанцэцэг *

Монголын түүх, дэлхийн түүхэнд тодорхой байр суурь эзэлдэг түүхэн үе, өөрөөр хэлбэл, XIII-XIV зууны Монголын түүх, Монголын эзэнт гүрний түүх цаг мөч улиран өнгөрөх тусам нэхэн нөхөн судлагдаж байгааг олон орны эрдэмтэн, судлаачдын бүтээл тууривал бэлхнээ харуулж байна. Зарим эрдэмтдийн тооцоолсноор дэлхийн 60 гаруй орон, бүс нутагт 400 гаруй судлаачид Чингис хааны тухай судлан бичсэн байна¹. Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ой судалгааныхаа хувьд арвин бүтээл тууривалтай золгож байгааг тэмдэглэхэд таатай байна. XIII-XIV зууны Монголын түүхийн судалгаа өнөөгийн даяаршиж байгаа ертөнцөд эрдэмтэд судлаачдын анхаарлыг улам бүр татах болсон нь дэлхийн талыг эзэмшсэн энэхүү том эзэнт гүрэн хэрхэн оршин тогтнож, олон улс орон, үндэстэн ястан, шашин шүтлэг, соёл иргэншил яаж мөр зэрэгцэн нэг гүрний хүрээнд зохицон оршиж байв аа гэдэгт зохих ёсны хариулт өгөхийг эрдэмтэд судлаачдаас улам бүр шаардаж байгаатай холбоотой юм. XIII-XIV зууны Монголын түүх, Монголын их гүрний түүхийн судалгаа өргөн цар хүрээг хамарч байгаагаас гадна тодорхой нарийн асуудал руу орж, гүнзгийрүүлэн нягтлан судлах, орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны үүднээс тодорхой асуудалд бодит хариу өгөхийг шаардсаар байна. Би энэхүү илтгэлдээ зөвхөн Чингис хааны үнэлгээний талаарх гадаадын судлаачдын, гэхдээ гол төлөв Оросын, Өрнөдийн, Хятадын судлаачдын үнэлгээний асуудалд анхаарлаа хандуулан дүгнэхийг зорилоо.

Монгол улс байгуулагдсан үйл явдал, Монголын их гүрний түүх нь Чингис хааны үйл ажиллагаатай нягт уялдаатай нь эргэлзээгүй. Энэ түүхэн хүний амьдрал, үйл ажиллагаа, оюун ухаан, удирдлагын арга барилыг судалж, ер нь Чингис гэж хэн байв? гэдэг асуулт дээр ч олон янзын дүгнэлт гаргаж, үнэлгээ өгч ирсэн, одоо ч өгсөөр байна.

* МУИС-ийн ОУХС-ийн захирал, профессор, доктор(Ph.D)

¹ Qian nian fengyun di yi ren / Мянганы цуут нэгдүгээр хүн/, Бээжин, 2005, дотор нүүрэн тал.

Гэхдээ энэ түүхт хүний судалгааны ажил өөрийн гэсэн онцлог, бартаат замыг туулж ирсэн нь сонирхол татаж байгаа юм.

Чингис хааны амьдрал, үйл ажиллагааг судалж, дэлхийн шинжлэх ухааны эргэлтэнд оруулах явдал Оросын дорнодахин судлалын шинжлэх ухааны үүсэл хөгжилтэй нягт уялдаатай гарч ирсэн юм. 1700 оны 6 дугаар сарын 18-нд Оросын Петр I хаан дорнодахины хэл судлах зарлиг гаргасны дотор монгол, хятад хэл сурахыг онцлон дурьдсан байдаг. 1716 онд Оросын анхны шашны төлөөлөгчид Бээжинд суурьших болсноос хойш оросуудын дунд дорнодахин судлалын ажлын суурь тавигдаж эхэлсэн юм.

Монголчуудыг бие даасан үндэстнийх нь хувьд судлан, монголын түүхийг тухайн үеийн хятад сурвалж материалд тулгуурлан судлах, босгох ажлыг анх гол төлөв Оросын шашны төлөөлөгч гэж нэрлэгдэх Оросын эрдэмтэд, хятад судлаачид хийсэн байдаг. 1729 онд Бээжинд сурч байсан, Эрхүү хотын Вознесенскийн хийдэд 15 жил ажиллаж байсан, монгол-оросын сургуулийн шилдэг сурагчийн нэг И.Россохин Монголын түүхийн эх материалыг хятад сурвалжаас орчуулах ажлыг нэлээд хийсэн байдаг.

Хятадад 14 жил амьдарч (1807-1821) хятад хэл сурч, хятад судлал руу гүнзгий орсон Оросын нэрт дорнодахин судлаач Никита Яковлевич Бичурин (1777-1853) 1799 онд Казанийн Шашины Академи төгсөөд (грек, латин, франц хэл эзэмшсэн байв) 1807 оноос Оросын шашны төлөөлөгчийн 9 дэх тэргүүнээр Бээжинд томилогдож ажиллахдаа Хятадыг судлахын хажуугаар Хятадын гадаад эзэмшил гэж нэрлэгдэх Монгол, Төвд, Шинжааны судалгаанд анхаарлаа хандуулан судалсан байдаг. 1828 онд “Монголын тухай тэмдэглэлүүд”² 2 боть зохиолоо хятад эх сурвалжид тулгуурлан хэвлэн гаргасан байдаг. 1829 онд “Чингисийн угсааны эхний 4 хааны түүх”³ номоо бичсэн байдаг. Энэ номондоо Чингис, Өгөөдэй, Гүюг, Мөнх хааны засаглалын үеийн түүхийг хятад сурвалж ашиглан гаргаж тавьсан байдаг.

1829 онд Чингис хааны тухай анхны европ судалгааны зохиол хэвлэгдэн гарсан нь хойшид ч олон орны эрдэмтэд, судлаачдын хүртээл болж, XIII-XIV зууны Монголын түүх, улмаар Чингис судлалын эхийг тавьсан юм. Түүний судалгааны бүтээлийг Орос оронд төдийгүй Европт өргөн ашигласан байдаг. Н.Я.Бичуриний дорнодахины судлалын шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг үнэлж Оросын Шинжлэх Ухааны Академийн сурвалжлагч гишүүнээр сонгосон байдаг.

² Записки о Монголии, СПб., 1828

³ История первых четырех ханов из дома Чингисова, СПб., 1829

Оросын шашны төлөөлөгчийн нэг, санваартан эрдэмтэн Петр Иванович Кафаров (1817-1878) - архимандрит Палладий 1841 онд Оросын шашны төлөөлөгчийн 12 дахь удаагийн бүрэлдэхүүнд орж Бээжинд очсон байдаг. Хятадад нийтдээ 30 жил гаруй амьдрахдаа⁴ маш их судалгааны ажил хийсэн. Түүний зохиосон “Хятад-орос толь”, “Эртний буддизмын түүхэн товчоон”, мөн түүний санаачилгаар бичигдсэн “Бээжин дэх Оросын шашны төлөөлөгчийн гишүүдийн бүтээл” хэмээх 4 боть ном зэрэг нь Орос оронд хятад судлалыг хойшид хөгжүүлэх суурь бүтээлүүд болсон байдаг. 1853 онд “Чингис хааны тухай монголын хуучны домог”, “Даосийн гэлэн Чаньчуны баруун зүгт хийсэн замын тэмдэглэл” зохиолуудыг хятад хэлнээс орчуулж тайлбар хийж хэвлэсэн байдаг. Эдгээр өгүүлүүд 1866 онд “Бээжин дэх Оросын шашны төлөөлөгчийн гишүүдийн бүтээл”-ийн IV ботид анх хэвлэгдэн гарч,⁵ “Чингис хааны тухай монголын хуучны домог” нь 1877 онд “Восточный сборник”⁶ сэтгүүлд дахин хэвлэгдсэн нь өрнө, дорнын судлаачдад Чингис хаан, түүний улс, гүрнийг үргэлжлүүлэн судлах боломжийг олгосон юм. П.Кафаров Чингис хааны тухай монгол домог гэж нэг бичээд Чингис хааны тухай хятад домог гэж нэг бичиж байсан нь сонирхол татаж байгаа юм. Үүнд Чингис хааны тухай энэ түүх хятадууд бичсэн үү, монголчууд бичсэн үү гэдэгт бас нэг эргэлзэж байсан тал бий болов уу гэж бодогдож байгаа юм. П.Кафаров нь түүх, хэл, газарзүй, шашны шинжлэх ухааныг хослуулан эзэмшсэн сонгодог хятад судлаач байснаас гадна нүүдэлчин Монголын түүхийн эх сурвалжийг дэлхийд нээж өгсөн гавъяатай эрдэмтэн билээ. Хятад сурвалж бичиг “Юаньчао би ши”- гээс “Монголын нууц товчоо”-г нээн орчуулж илрүүлчихээд, түүний эх сурвалжийг - монгол эхийг олж чадаагүйдээ харамсан насыг нөхцсөн юм.

1716 оноос гараагаа эхэлж 100 гаруй жил Бээжинд үйл ажиллагаагаа явуулсан Оросын шашны төлөөлөгчийн газрын санваартан-эрдэмтэд И.Россохин, Никита Яковлевич Бичурин, Петр Иванович Кафаров нар Оросын дорнодахин судлал-хятад судлалын эхийг тавихын хамт монгол судлал түүний дотор Чингис судлалын эхийг тавьсан байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй юм.

Он дараалал, түүхэн үйл явцыг тоочин бичиж хадгалдаг уламжлалтай Хятадын түүх бичлэгт хадгалагдан үлдсэн Монголын түүхийн эх сурвалж материалуудыг орос хэлнээ

⁴ Г.В.Ефимов.Историко-библиографическое обозрение источников и литературы по новой истории Китая,издательство ЛГУ, 1968, часть II., стр.29

⁵ Труды членов Российской духовной миссии в Пекине, т. 1У,1866, стр.1-258, стр.259-434

⁶ Палладий, архимандр. Старинное китайское сказание о Чингис-хане, Перевод с китайского- “Восточный сборник” 1877, т1, стр. 149-294

орчуулж, тайлбар хийн, учрыг нь олж хужрыг нь тунгаах зорилготой хийгдсэн анхны судалгааны бүтээлүүдийг хэвлэн нийтлэх явдал эрдэмтэд судлаачдын нөр их хичээл зүтгэл, хэлний асар өргөн болон гүнзгий мэдлэг, (И.Россохин хятад, манж, монгол хэл, Н.Я.Бичурин грек, латин, франц, хятад, П.Кафаров хятад, монгол, манж хэлийг гарамгай эзэмшсэн байдаг), түүх, газар зүй, шашин, соёлын шинжлэх ухаануудыг хослуулан эзэмшсэн эрдэм мэдлэгийн өндөр чадварыг шаардсан байсан юм. Чингис хааны судалгаанд одоогоос бараг 200-гаад жилийн өмнө гадаадын эрдэмтэд анхаарлаа хандуулж бүтээл тууривалдаа тусгаж, судалж эхэлсэн байна. Гэвч Чингис хааны судалгаа, хамгийн гол нь түүнд өгөх үнэлгээ, үзэл баримтлал одоог болтол шинжлэх ухаанд маргаантай, олон, тэр битгий хэл эсрэг тэсрэг үзэл баримтлал, үнэлгээ дүгнэлтийг агуулсаар байгаа нь сонирхол татаж байгаа юм.

XIX зууны эхэн гэхэд Чингис хаан, түүний үйл ажиллагааны талаар хийгдсэн Оросын эрдэмтдийн шинжлэх ухааны нээлтүүд өөрийн үнэлгээ дүгнэлтүүдийг тодорхой хэмжээгээр шаардах болсон байсан.

1826 онд Оросын ШУА тухайн үеийн эрдэмтдийн өмнө нэгэн зорилт тавьсан нь “Орост монголчууд ноёрхож байсан нь ямар үр дагаварт хүргэв, монголчуудын дарангуйлал Орос орны улс төрийн харилцаа, засаглалын дэглэм, төрийн удирдлага болон ард түмний гэгээрэл боловсролд ямар нөлөө үзүүлэв” гэсэн асуултанд хариу өгөх захиалгат судалгааг 1829 оны 1 дүгээр сарын 1-нд хүлээн авахаар зарласан байдаг. Товлосон хугацаанд герман хэл дээр бичигдсэн нэг л бүтээл ирсэн боловч түүнийг болзол хангах хэмжээнд хүрээгүй гэж үзсэн байдаг. 1832 онд дахин шийдвэр гаргаж зорилгоо “Зүчийн буюу Алтан ордны улсын түүхийг дорнодахины, ялангуяа лалын түүхчдийн бүтээл тууривал, монгол хаадын удмаас хадгалагдаж үлдсэн түүх дурсгал болон эртний Орос, Польш, Унгарын түүх шаштир, түүнчлэн орчин цагийн европчуудын зохиол бүтээлд тэмдэглэгдэн үлдсэн баримт мэдээллүүдэд үндэслэн бичих” хэмээн тодорхойлсон байдаг. Энэ зорилгоо хэрэгжүүлэх хугацааг 1835 оны 8 дугаар сарын 1 хүртэл тогтоожээ. Энэ хугацаанд мөн герман хэлээр бичигдсэн томоохон судалгааны бүтээл ирснийг төдийлэн сайшааж үзээгүй байна. Энэ бүтээлд академич Френ, Шмидт, Круг нар шүүмж бичиж буцаасан байдаг.

XIX зууны эхэн гэхэд Орос оронд дээд боловсролын хэмжээнд сургалт судалгааг хослуулж, Дорнодахины түүх, Монголын түүхийг тодорхой хэмжээгээр заадаг байв. Дорнодахины түүх, Монголын түүхийг биеэ даасан шинжлэх ухааны салбар болгон судлах

ажил Оросын шинжлэх ухааны байгууллага байгуулагдахаас өмнө Их дээд сургуулиудад явагдаж байсан нь тухайн үеийн эрдэмтэн багш нарын бүтээлээс илт байдаг юм. Тухайн үед Петербургийн Их сургуулийн Дорнодахин судлалын тэнхэмд түүхийн багшаар ажиллаж байсан нэрт түүхч-дорнодахинч эрдэмтэн В.В. Григорьев (1816-1881) (Алтан орд, Дундад Ази болон Монголын харилцааны түүхийн хичээл заадаг байв) нэрт монгол судлаач, мөн тэр сургуулийн багш А.В. Попов (1808-1865) (Чингис хааны үеэс эхлэн XIX зууны дунд үеийг хүртэлх үеийн Монголын түүхээр лекц уншдаг байв), нэрт монгол судлаач А.М. Позднеев (1851-1920) мөн тус сургуульд багшилж байсан (П.Кафаров өөрийн “Монголын нууц товчоог” Позднеевт шилжүүлэн хүлээлгэн өгснөөр Позднеев “Нууц товчоог” судлаж эхэлсэн) зэрэг нэрт эрдэмтэд монгол судлалд үнэлж барахгүй хувь нэмэр оруулсан байдаг. Гэвч Монголын түүхийн талаарх эрдэмтдийн судалгааны шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлт нь тухайн үеийн Хаант Оросын Чингист өгөх “үнэлгээ” үзэл баримтлалтай харшилж байсан учир эрдэмтэд ихээхэн хэлмэгдэж, судалгааны үр дүн хэрэгсэхгүй байдалд орсон байдаг. Тухайлбал, Казанийн Их сургуулийн монгол хэл, уран зохиолын ууган профессор, Петербургийн Их сургуулийн Монгол-халимаг хэлний тэнхмийн эрхлэгчээр ажиллаж байсан нэрт эрдэмтэн Александр Васильевич Поповыг ид лекцээ уншиж байхад нь 1857 онд Баруун Сибирийн дунд сургуульд шилжүүлсэн байдаг. Нэрт эрдэмтэн Алексей Матвеевич Позднеев хэдийгээр Оросын монгол судлалд гарамгай гавьяа байгуулж, олон экспедици зохион байгуулж, арвин их судалгааны ном зохиол тууриван бүтээсэн ч түүнийг 1899 онд Владивосток дахь Дорнодахин судлалын хүрээлэнгийн захирлаар “томилсон” боловч 1903-1917 онд засаг захиргааны ажилтан болон хувирсан байна. 1917 онд Санкт-Петербургийн Их сургуульдаа эргэж ирсэн боловч төдөлгүй 1919 оноос гадаадад гарч 1919-1920 онд Данийн Их сургуульд ажиллаж байгаад 1920 оны 9 дүгээр сарын 30-нд нас нөхцсөн байна.

Хаант Оросын үеэс эхлэн Орос орон бодлогынхоо хүрээнд Чингис хааны талаар судалгаа хийж, шинжлэх ухааны бодит үнэлгээ дүгнэлт хийсэн, хийхийг оролдсон эрдэмтэн судлаач хэн боловыг ч төрийн бодлогын үзэл баримтлалтай харшилдаж байгаа үүднээс хэлмэгдүүлэн хавчиж ирсэн байна.

А.М.Позднеевын дараа ч Монголын түүхийн асуудлаар ялангуяа Чингис, түүний байлдан дагуулалт, үйл ажиллагааны талаар судалсан эрдэмтэн судлаачид хэлмэгдсээр ирсэн ба Чингис хааны талаар туурвисан ном бүтээлүүдийг нь хориглох, шүүмжлэх, түүний хэргээр ажлаас нь халах, шоронд хийх хүртэл арга хэмжээ авахуулж байсан байна.

А.М.Позднеевын дараа Петербургийн Их сургуулийн монгол-халимаг хэл зохиолын тэнхмийн эрхлэгчээр 1918-1924 онуудад ажиллаж байсан В.Л.Котвич Польш руу гарч явсан ба 1907 оноос мөн сургуульд ажиллаж байсан Цэвээн Жамцарано (1880-1940) 1937 онд нэг хүнийг тахин шүтэх хэргээр баривчлагдаж 1940 онд ГУЛАГ-ийн шоронд нас барсан.

XIX Хэдийгээр цаг хатуу, монгол судлаач ялангуяа монголын түүх судлаачид удаа дараалан хэлс хэрэгт хэлмэгдэж байсан ч оросын эрдэмтэд судлаачид судалгааныхаа ажлаа үргэлжлүүлэн явуулсаар байв. XIX-XX зууны зааг дээр герман гаралтай эрдэмтэн, академич Василий Владимирович Бартольд (1869-1930) “Чингис хааны эзэнт гүрэн бүрэлдэн тогтсон нь” сэдвээр 1896 онд Петербургийн Их сургуульд лекц уншиж байсан байна. Төдөлгүй 1900 онд “Монголын довтолгооны үеийн Туркестан” алдарт бүтээлээ хэвлүүлэн гаргасан байдаг. Уг бүтээлдээ Чингисийн эзэнт гүрний төр, цэргийн зохион байгуулалтыг судалж шинжлэх ухааны үүднээс дүн шинжилгээ хийсэн нь Орос болон хилийн чанадад асар их нэр хүндтэй бүтээл болсон байдаг. Уг зохиол 1928 онд англи хэлээр, 1931 онд узбек хэлээр, 1958 онд англи хэлээр дахин хэвлэгдсэн байдаг.

В.В.Бартольд “Чингисийн төрийн байгуулал нь язгууртан сурвалжитны засаглал байсан” хэмээн дүгнэсэн байдаг. “Нүүдэлчдийн асар том эзэнт гүрэн үүсэн тогтнох явдал Дундад Азийн түүхэнд байнга давтагдаж байсан ба энэ нь эдийн засгийн шалтгаантай байсан юм” гэж дүгнэхийн сацуу Чингис хааны зохион байгуулах чадварыг ихэд үнэлэн, Чингис хаан нүүдлийн соёлыг, суурин соёлтой эвлэрүүлэхийг эрмэлзэж байсан гэж дүгнэсэн нь одоогийн эрдэмтдийн үзэл баримтлалтай тохирч байгаа юм. Гэвч В.В.Бартольд Чингис хааны үйл ажиллагааны сул талыг хоёр өөр соёлыг эвлэрүүлэх гэсэнд оршино гэж дүгнэсэн байдаг. В.В. Бартольд: “нүүдлийн амьдрал ахуй болон суурин соёлыг эвлэрүүлэх гэсэн эрмэлзлэл нь Чингис хааны ноёрхлын систем дэх хамгийн сул тал, сүйрэл, унах гол шалтгаан нь болсон” гэж үзсэн байдаг.

В.В.Бартольд Монголчуудын байлдан дагуулалт, Чингис хааны тухай судалж түүнийг үнэлэхдээ: “Чингис хаан өөрийн үе залгамжлагчиддаа зэвсгээр байлдан дагуулсан асар том эзэнт гүрнийг үлдээсэн төдийгүй бас түүнийг удирдах эх үндсийг үлдээж өгөөд 1227 оны VIII сард өөд болсон” гэж бичсэн байдаг. “Улс орнуудын хоорондын худалдааг өргөжүүлэх, соёлын холбоог бэхжүүлэхэд Чингисийн эзэнт гүрэн их хувь нэмэр оруулсан. Чингис хаан бол ер бусын стратегич, жанжин, төрийн том зүтгэлтэн байсан” гэсэн үнэлгээг XIX-XX зууны зааг дээр Санкт-Петербургийн Дорнодахины факультетэд уншиж

байсан лекцүүд болон “Чингис хааны эзэнт гүрэн байгуулагдсан нь” өгүүлэлдээ бичсэн байдаг. В.В.Бартольд араб, перс, исламын бусад хэл дээрх эх сурвалжид тулгуурлан Чингис болон Монголын Их гүрний судалгаа хийхдээ Монголын нийгмийн үйл явцад гүнзгий орж, шинжлэх ухааны үнэлэлт дүгнэлт хийснээрээ онцлог юм.

XX зууны эхэнд Оросын монгол судлал оргил үедээ хүрэх явдал Б.Я.Владимирцовын судалгаа, Монголын нийгэмд өгсөн шинжлэх ухааны үнэлгээтэй салшгүй холбоотой юм. Борис Яковлевич Владимирцов (1884-1931) англи, франц, монгол, төвд, санскрит, араб хэл мэддэг байв. Монгол хэл, уран зохиол шашин, нийгэм, төр, түүхийг судлах явцдаа мөн Чингис хаан, түүний үйл ажиллагааг судалж, “Чингис хаан” номоо бичсэн байдаг. Гэвч түүний ном тухайн үедээ нилээд шүүмжлэлтэй тулгарч, Орос оронд хэвлэгдээгүй. В.В.Бартольд Владимирцовыг “Чингис хааныг магтан дуулсан” гэж шүүмж бичсэн байдаг. Якубовский уг номыг “дэвшилтэт биш судалгаа” гэж үнэлсэн нь тухайн үеийн Оросын монгол судлалд Чингис хаан, Монголын эзэнт гүрний талаархи төрийн үзэл баримтлал эрдэмтдийн үнэлгээнээс ихээхэн ялгаатайгаар барахгүй эрдэмтдийн бүтээлийг хэвлүүлэхгүй хорьдог болсныг гэрчилж байна. Б.Я.Владимирцов тэр үед “Чингис хаан бол тухайн цаг үеийнхээ хүү, ард түмнийхээ хүү нь байсан. Тийм учраас түүнийг тэр үеийнх нь нөхцөл байдалд өөрийнх нь орчин тойронг оролцуулан дүгнэж үзэхээс биш, өөр үед дэлхийн бөмбөрцгийн өөр газар шилжүүлэн үзэж болохгүй” гэж бичсэн байдаг. Б.Я.Владимирцовын монгол нийгэм, ахуй, ёс заншил, хэл, монголчуудын сэтгэхүйг гарамгай сайн мэддэг явдал нь түүний монгол судлалд нээлт хийхэд чухал хүчин зүйл болсон байдаг. Б.Я.Владимирцовын “Чингис хаан” ном 1922 онд анх Берлинд орос хэлээр хэвлэгдэн гарч, 1926 онд франц, 1930 онд англи, 2001 онд монгол хэлнээ орчуулагдсан. Энэ номыг англи хэлнээ хэвлэгдмэгц Филадельфигээс Америкийн улс төрийн нийгмийн шинжлэх ухааны академийн гишүүн болгохоор Владимирцовт урилга ирүүлж байсан байна. Халимгийн эрдэмтэн Хар Даваагийн бичсэн “Чингис хаан” зохиол мөн гадаадад хэвлэгдэн гарчээ.

Оросын эрдэмтэд XIX–XX зууны эхэн хүртэл хэдийгээр Чингис хааны талаар баримтлах улс төрийн үзэл баримтлалд хавчигдаж байсан боловч эрдэмтэн хүний ёс жудаг баримтлан шинжлэх ухааны эрэл хайгуулаа хийж, үнэлгээ дүгнэлт өгсөөр, бүтээл, номоо туурвисаар ирсэн байна. Б.Я. Владимирцовоос хойш Чингис хааны талаар Орос оронд дорвитой, шинжлэх ухааны үндэслэлтэй бүтээл гарах боломж бүрмөсөн хумигдаж,

Г.В. Вернадскийн тодорхойлсноор “Оросын түүхийн шинжлэх ухааны мөхлийн үе” ирсэн байв.

Зөвлөлт засгийн жилүүдэд Чингисийн талаарх бодит судалгаа бүрмөсөн хоригдож, Чингис хаан ба түүний байгуулсан Их гүрний түүхийг зөвхөн сөрөг талаас нь бичих, Чингис хааныг “алуурчин”, “түйвээн сүйтгэгч”, “бүдүүлэг зэрлэг”, түүний байгуулсан Их гүрнийг дэлхийн түүхийн хөгжлийг хойш нь татсан, дэлхийн хөгжилд зөвхөн хор хохирол учруулсан мэтээр бичих үзэл баримтлалыг баримталж, энэ үзэл баримтлалыг дагаагүй олон эрдэмтэн, судлаачдыг хэлмэгдүүлж байсан.

Өрнөдөд, ялангуяа АНУ-д монгол судлал Оростой харьцуулахад хожуу, тухайлбал XX зууны эхнээс хөгжиж эхэлсэн. Үүнд газар нутгийн хол байдал, Монгол улс өрнөдийн орнуудтай албан ёсны харилцаа тогтоогоогүй байсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн болно. Хэдий тийм ч монголчуудын түүх, соёлын асуудлаас хамгийн анхаарал татаж судлагдсан сэдэв бол XIII-XIV зууны Монголын түүх байжээ. Өрнөдийн судлаачид XIII зуунд Монголд ирж 17 жил амьдарсан Италийн алдарт жуулчин Марко Пологийн тэмдэглэл, дурсамжуудыг орчуулан, судлахад ихээхэн анхаарсан байдаг. 1903 онд Лондонд Jule Henry “Марко Пологийн ном”-г⁷ Henry Cordier-ийн хянан тохинуулснаар англи хэлнээ орчуулсан байдаг. Olschki, Leonardo “Марко Пологийн урьдчилсан төсөөлөл” номоо 1943 онд, Latham Ronald “Марко Пологийн жуулчлал” номоо 1958 онд, Micheli Silvio “Марко Пологийн болон бусад аялагчдын тэмдэглэл дэх Монгол” номоо 1967 онд хэвлүүлснээс гадна 1960 онд “Марко Пологийн Ази” нэртэй номыг Калифорны Их сургууль хэвлэн гаргасан байна.⁸

Мөн Плано Карпинийн Монголын талаар бичсэн тэмдэглэл хийгээд Поп IV Иннокентээс Монгол хаадад илгээсэн захидал, Вильям Рубрук-ийн тэмдэглэл, Джон Монте Корвино болон ах дүү Перугау нар Монгол хаадтай харилцаж байсан захидлуудыг эмхтгэн нийтлэх, судлан шинжлэх ажил хийгдсэн байна.⁹

Christopher Dawson “Монгол элч. XIII-XIV зууны үеийн Монгол ба Хятадад байсан Францын шашин номлогчдын захидал, өгүүлүүд”¹⁰ хэмээх номоо 1955 Нью Йорк хотноо хэвлүүлсэн байна. Мөн 1966 онд Нью Йоркт “Азид илгээсэн элч” хэмээх ном

⁷ Jule Henry, trans. *The book of Ser Marco Polo, the Venetian, Concerning The Kindoms and Marvels of the East*, 2 vols, 3rd ed. rev. by Henri Cordier, London, 1903

⁸ Olschki, Leonardo. *Marco Polo's Precursors*, Baltimore, 1943; Latham, Ronald. *The Travels of Marco Polo*, Harmondsworth, Penguin, Books, 1958; Micheli Silvio, *Mongolia: In search of Marco Polo and other Adventures*, New York, 1967; *Marco Polo's Asia*, Berkeley, University of California, 1960

⁹ *Mission to Asia*, New York, 1966

¹⁰ Christopher Dawson. *The Mongol Mission. Narratives and letters of the Franciscan missionaries in Mongolia and China in the Thirteenth and Forteenth centuries*, New York, 1955

хэвлэгдэн гарсан нь тухайн үед Монголд ирж байсан жуулчин, шашин номлогчдын өгүүлэл, тэмдэглэлийг үндэс болгон Монголын нийгмийг судлах ажилд анхаарч байсныг гэрчилж байна.

1925 Impey Lawrence Газарзүй судлалын сэтгүүлд “Шанду– Хубилай хааны зуны нийслэл” өгүүллээ хэвлүүлсэн байдаг.¹¹ 1948 онд Харвардын “Ази судлалын сэтгүүлд” Cleaves Francis Woodman “Монголын нууц товчоон дахь Job Esebol-ын тусгал”¹² өгүүллээ хэвлүүлсэн байдаг. Мөн сэтгүүлд 1951, 1952 онуудад “XIII-XIV зууны монголчуудын бичиг хэрэг хөтлөх туршлага”,¹³ “1346 оны хятад-монголын бичиг”¹⁴ өгүүллүүд хэвлэгдсэн байдаг. 1982 онд Кимбридж Харвардын Их сургуулийн хэвлэлийн газар “Монголын нууц товчоо”-г¹⁵ хэвлэн нийтлүүлжээ.

Монголын эзэнт гүрний түүхийн судалгааг нарийвчилсан тодорхой сэдэв, асуудлын хүрээнд судлах явдал хийгдэж ирсэн байна. Энэ нь нарийнаас тойм руу, тодорхойгоос ерөнхий рүү ордог өрнөдийн судалгааны арга зүйтэй ч холбоотой юм.

1953 онд Vreeland, H.H. “Монголчуудын нэгдэл ба Монголын хаант төрийн бүтэц”¹⁶ бүтээлээ хэвлүүлсэн байдаг.

Дэлхийн II дайны дараагаар өрнөд рүү гарсан хятад судлаач, монгол судлаач эрдэмтэд монгол судлал хөгжүүлэхэд ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг. Сэжин Жагжид гуайн судалгааны бүтээлээс сэдэвтэй холбогдуулан дурьдахад монгол судлаач Воудений хамт “Юань гүрний морины бодлогын тухай зарим тэмдэглэл”¹⁷ зохиолоо Төв Ази судлалын сэтгүүлд 1965 онд хэвлүүлсэн байдаг. Dardess John “Байлдан эзлэгчид ба Күнзчүүд: Юань гүрний сүүл үеийн Хятадын улс төрийн өөрчлөлтүүд”¹⁸ номоо Нью Йорк хотноо 1973 онд хэвлүүлсэн байдаг.

Аливаа татварыг бид алба, гувчуур хэмээн нэрлэж дарлагч ангийн хэрэгсэл мэтээр ойлгож, түүнийг зөвхөн муу тал, сөрөг үр дагавартай мэт бичиж байсан энэ үед Харвардын Их сургуулийн Ази судлалын сэтгүүлд Smith J.M. “Монгол ба нүүдэлчдийн

¹¹ Impey, Lawrence. “Shang-tu, Summer Capital of Khubilai Khan”, *Geographical Review*, Oct, 1925

¹² Cleaves, Francis Woodman. “The Expression Job Esebol in the Secret History of the Mongols” *Harvard Journal of Asiatic Studies*, 11 (1948) 311-20

¹³ A Chancellery Practice of the Mongols in the Thirteenth and Fourteenth Centuries, 14 (1951)

¹⁴ The Sino-Mongolian Inscription of 1346, 15 (1952), 1-123

¹⁵ The Secret History of the Mongols, Cambridge, Harvard University Press. 1982

¹⁶ Vreeland, Herbert Harold, III. *Mongol Community and Kingship Structure*, New Haven, Human Relations Area Files, 1953

¹⁷ Jagchid, Sechin and Bawden, Charles R. “Some Notes on the Horse Policy of the Juan Dynasty”, *Central Asiatic Journal*, Dec, 1965

¹⁸ Dardess, John W. *Conquerors and Confucians: Aspects of Political Change in Late Juan China*, New York, 1973

татварын алба”¹⁹ өгүүллийг хэвлэн нийтэлж, сонирхолтой судалгаа хийсэн байдаг. Нийгмийн түүхийг судлахдаа үйл явдлыг хувь хүнтэй, эзэнтэй нь судлах явдал өрнөдийн түүхийн шинжлэх ухааны онцлог байдаг. XIII-XIV зууны Монголын түүхийн судалгаанд ч энэ бас хамааралтай явагдаж ирсэн.

1979 онд Америкийн Миннесотын Их сургуульд Allsen Thomas “Монголын эзэнт гүрний бодлого: Мөнх хааны хаанчлалын үеийн төвлөрүүлэх ба нөөц хүчийг дайчлах бодлого” сэдвээр эрдмийн зэрэг Ph.D хамгаалж, энэ ажил нь “Монголын эзэнт гүрэн”²⁰ нэртэйгээр хэвлэгдэн гарсан байдаг. 1987 онд Харвардын Их сургуульд Steinhardt N.S. “Монголын ивээл доорх эзэнт гүрний хот байгуулалт: Дадү - Хубилайн эзэнт гүрний хот болох нь”²¹ сэдвээр мөн эрдмийн зэрэг Ph.D хамгаалсан байдаг. Америкийн Колумбын Их сургуулийн профессор, нүүдэлчид ба суурин хятадын харилцааны түүхийг олон жил судалж бүтээл зохиолоо тууриваж, үнэтэй хувь нэмрээ оруулсан эрдэмтэн Моррис Россабид 1988 онд “Хубилай хаан, түүний амьдрал ба эрин үе”²² зохиолоо бичиж хэвлүүлсэн байдаг.

Өрнөдөд XIII-XIV зууны Монголын Их гүрний түүхийн судалгаа, “нууц товчоо” судлалын ажил хүйтэн дайны үед ч хийгдэж байсан байна. Өрнөдийн эрдэмтэд Чингис хаанд өгсөн үнэлгээний талаар анхнаасаа Оросын болон бусад орны зарим эрдэмтдийн үзэл бодлоос өвөрмөц өнөөгийн өндөрлөгөөс авч үзвэл илүү бодит үнэлгээ өгч байсан байх юм. Тухайлбал, Францын эрдэмтэн Abel Remusat бүр 1829 онд “Чингисээс Доголон Төмөр хүртэлх Монголчуудын түүх” гэдэг номонд шүүмж бичихдээ: “Д’Оссоны бичсэн зүйл нь түүхий нь бичихээр шийдсэн ард түмнийг нааштай харж бичсэн гэх аргагүй байна. Монголчуудыг тоо томшгүй харгислал, аллага хядлага үйлдсэн хэмээн зэмлэн буруушаажээ. Мэдээжээр ийм зэм бурууг Монголчууд хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Монголчууд түүхэнд гарч ирсний дараа асар их аллага хядлага үйлдсэн нь үнэн бөгөөд энэ ял зэмийг монголчуудад ноогдуулах нь зүйн хэрэг. Гэвч байлдан дагуулж, алдар нэрээ мандуулах явдал аливаа ард түмний түүхэнд ямагт гардагийг бодолцох хэрэгтэй. Гагцхүү ийм явдал хийсэн аль нэг ард түмнийг онцгойлон үзэж ял зэмээс хэлтрүүлж болох мэтээр ойлгохгүй байх нь л чухал. Монголчуудын байлдан дагуулалт өргөн уудам зайд явагдсан,

¹⁹ Smith, John Masson. “Mongol and Nomadic Taxation”, *Harvard Journal of Asiatic Studies*, 1970, 30, p. 46-85

²⁰ Allsen, Thomas. T. “Politics of Mongol imperialism: Centralization and Resources Mobilization in the reign of the Grand Qan Mongke, 1251-59. Ph.D. Diss. University of Minnesota, 1979, *Mongol imperialism*

²¹ Steinhardt, Nancy Schatzman, *Imperial Architecture under Mongolian Patronage: Khubilai's Imperial City of Da-du*, Ph.D., Harvard University, 1987

²² Morris Rossabi. *Khubilai Khan. His life and times*. University of California press. Berkeley, Los Angeles, London. 1988

гэвч Грек, Ромчуудын харгислал нь явцуу уйтан орчинд болсноороо монголчуудын харгислалаас арай зөөлөн аядуу байсан гэж үзэх ямар ч үндэсгүй. Түүнчлэн Чингис чадварлаг төрийн зүтгэлтэн, агуу их жанжин, тэр ч байтугай хууль дүрэм тогтоох талаар авъяаслаг хүн байсныг үл хүлээн зөвшөөрөх нь шударга бус хэрэг болох бизээ”²³ гэж бичсэн байдаг.

Чингис хаан, түүний үйл ажиллагааны тухай өрнөдийн судлаачид XX зууны эхнээс идэвхтэй сонирхон судалж, судалгааны объект болгон бүтээл тууривалаа гаргаж эхэлсэн байдаг. Германы эрдэмтэн F.Krause өөрийн бүтээлдээ “Чингис хаан бол дэлхийн түүхийн хамгийн том хүмүүсийн нэг бөгөөд түүний амьдрал, үйл нь асар их анхаарал татдаг”²⁴ хэмээн 1922 онд бичсэн байдаг. Мөн Английн эрдэмтэн R.Fox “Бабур, Тамирлан нар агуу их хүмүүс боловч Чингис ба түүний гарамгай аймгийн бүтээсэн зүйлийн хагасыг нь ч бүтээж чадаагүй юм” гэж 1930 онд Нью Йорк хотноо хэвлүүлсэн “Чингис хаан”²⁵ бүтээлдээ үнэлсэн байна.

Францын эрдэмтэн A.Ekkaes 1933 онд бичихдээ “Ромын пап лам, хөрөнгөлөг худалдаачид, загалмайтны үзэл суртлыг хөхиүлэн дэмжиж, тэдний гараар улс төр, эдийн засгийн зорилгоо биелүүлэх гэсэн санаархал нь бүрэн балран унасан юм. Харин баруун Европын эрх баригчдын өмнөө тавьж байсан зорилгын зарим хэсгийг Монголын эзэнт гүрэн, Монголын байлдан дагуулагчид гүйцэлдүүлэн хийж, улмаар Дорно, Өрнө дахины бие биеэсээ урьдын адил нуугдмал байдаг байдал нь анх удаа арилав. Хамгийн тэргүүнд худалдаачид алс холын орон нутагтай шууд харилцах болж, Араб, Перс төдийгүй Итали, Европын бусад орны харъяатнаар дорно зүгийн улс төр худалдааны төвтэй харилцаа холбоо байгуулжээ. Худалдаачид, инженер, цэргийн мэргэжилтэн, эмч нарын дараа Европын улс гүрэн Монголын хаадтай элчин төлөөлөгчид солилцох болов. Улс төрийн ба цэргийн тагнуулууд лам хуврагын дүрээр Төв Азийн орнуудад хүрэлцэн ирж эрдэм шинжилгээ болон цэрэг дайны чанартай мэдээ сэлтийг судлах болов. Монголын цэрэг Саксон ба Атриатын тэнгис хүртэл ялгуулсан аян дайн хийж, Ази тивийнхэнд алс өрнөдөд орших аж ахуй, соёлыг бас уламжлан танилцуулах болсноос гадна Монголын байлдан дагуулагчид нутагтаа аваачсан олон тооны гар урчууд, мөн өөрийн аж ахуй, гар урлалын ололт амжилтаа танилцуулах болсон байна”²⁶ гэж бичжээ.

²³ Abel Remusat. *Nouveaux melaudes asiatiques*. Paris. 1829

²⁴ F. Krause. *Cingis Han. Die Geschichte seines Leben nach den chinesischen Reichsannalen*. Heidelberg. 1922

²⁵ R. Fox. *Genghis Khan*. New York, 1930

²⁶ A.Ekkaes. *Middle ages and Russia*. Paris. 1933

Лондоны Дорнодахин, Африк судлалын сэтгүүлд Poliak A.N.-ийн “Чингис хааны Их засаг хуулийн ерөнхий нөлөөлөл. Мамлюк улсын зохион байгуулалт.”²⁷ өгүүлэл 1939 онд хэвлэгдэн гарч байсан байна. Германы эрдэмтэн B.Spuler “Монголчуудын өмнөө тавьсан зорилго нь тэдний эзэн хаан Чингисийнхтэй адил байв. Тэрхүү зорилго төлөвлөгөөг талын язгууртнууд боловсруулжээ. Тэд том хүчирхэг гүрэн байгуулж, эрх мэдлээ дэлхий даяар дэлгэрүүлэхийг чармайж байлаа. Энэ нь цоо шинэ үзэл санаа биш боловч бодитойгоор биелж байсангүй. Түрэмгийллийн шинэ үзэл санааг Монгол улсыг хөгжүүлэх зорилго бүхий хүмүүс дэвшүүлсэн бөгөөд түүнийг биелүүлж чадах хүн гэж Чингист найдаж байв”²⁸ гэж бичсэн нь зөвхөн нэг хүнд өгсөн үнэлгээ биш тэр үеийн Монголын нийгэмд өгсөн үнэлгээ байв.

1971 онд Boyle J.A. -ийн бичсэн “Чингис хааны үе залгамжлагчид”²⁹ нэртэй ном Нью Йорк хотод хэвлэгдэн гарсан байна. Мөн онд Английн нэрт монголч эрдэмтэн J. Saunders “Монголчуудын түүх”³⁰ номоо хэвлүүлж түүндээ Чингис хааныг хувь хүнийх нь хувьд ч, түүхэнд гүйцэтгэсэн үүргийнх нь хувьд үнэлэн “Чингис дайсан ба урвагчдад хатуу ширүүн, анд нөхөд нэгэн сэтгэлтэн нартаа ер бусын элэгсэг дотно, бас шинэ үзэл санааг хүлээн авамтгай, соёл иргэншлийн ололтыг үнэлж, түүний зарлиг тушаал нь Ази тивийн олон соёлын нэгдэн нийлэхэд хэзээ ч байгаагүйгээр их тус болжээ” гэж үнэлсэн байдаг.

1976 онд Brent P. “Чингис хаан. Монголын эзэнт гүрний сэргэн мандалт, засаглал, уналт”³¹ номоо Нью Йорк хотноо хэвлүүлэн гаргасан байна. Чингис хаан шинийг санаачлагч үлэмжийн их оюун билэгтэй байсныг өгүүлсэн зүйл Жүвэйний зохиолд ч тэмдэглэсэн байдаг. Жишээ нь: “Чингис хаан өөрийн оюун билэгт түшиглэж бусад орныг байлдан дагуулах аргыг олдог байсан ба дайсан этгээдийг сөнөөн устгах, дорхи хүмүүсийг дэвшүүлэн хэрэглэх зэрэг арга нь” цөм түүний оюун сэтгэлгээний үүдэлт, уран чадварынх нь гялалзсан бүтээл болно... Байдал байдалд нь зохицуулан заалт журам боловсруулна”³² хэмээн бичсэн байдаг.

Америкийн эрдэмтэн Halperin. Ch.J. 1983 онд Чингис болон түүний үе залгамжлагчдын Оросын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг “Орос дахь Монголын ноёрхол

²⁷ Poliak A.N. “The influence of Chingiz-Khan's Jasa upon the General. Organization of the Mamluk State.” *Bulletin of the School of Oriental and African Studies, London University*, 10, (1939-1942) 1862-76

²⁸ B.Spuler. *Die Goldene Horde. Leipzig. 1943, s.59*

²⁹ Boyle, John Andrew. *The Successors of Genghis Khan. New York, Columbia University Press, 1971*

³⁰ J. Saunders. *History of the Mongols. London, 1971, p. 65-67*

³¹ Brent, Peter. *Genghis Khan: The Rise, Authority and Decline of Mongol Power. New York, 1976*

³² Жүвэйни. *Дэлхийг байлдан дагуулагчийн түүх. Дээд дэвтэр. Хөх хот. 1989. 40 - 42 дахь тал.*

шууд бус дам хөндлөнгийн шинжтэй байжээ. Оросын хувьсгалын өмнөх буюу хойшхи үеийн Оросын түүхчдийн хараан бичсэнчлэнгээр Монголын ноёрхлын үед орос угсаатны оюун санаа, тэдний визант гаралтай үнэн алдартны шашны аль алиныг нухчин дарсан явдал гараагүй. Монголчууд Орост колоничлон суугаагүй, өөр үндэстэн угсаатан гэж дээрэлхээгүй... Ямар ч атугай Орос орныг Оросын ван нараар дамжуулан захирч байсан. Хэрэв Невийн Александр өрнө этгээдэд швед, тевтоны рыцариудтай байлдаж байсан бол монголчуудын эсрэг тулалдаж байсангүй. Харин монголчуудын эзэн эрхийг төвөггүй хүлээн зөвшөөрсөн юм. Монголын эрх баригчид Оросын сүм хийдийг албан татвараас чөлөөлж өөр бусад эрх дарх өгсөн нь үнэн алдартны шашин оросын зүүн хойд хэсэгт сэргэн мандахад асар их үр нөлөө үзүүлсэн юм. ...оросууд хожим их гүрний нэгэн бүрэлдэхүүн хэсэг болсноос хойш олон талын ашиг олж худалдаа арилжаа хөгжсөн байна”³³ хэмээн бичсэн нь урьдын монголчуудын Оросын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг үнэлж байсан үнэлгээнээс эрс ялгаатай байв.

Дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн Чингисийн үүргийг Германы эрдэмтэн P. Ratehnevsky “Чингис хааны дэлхийн хэмжээний их гүрэн байгуулах бодлогын чиг баримтлал бол шинэ зүйл юм. Түүнийг нас барсны дараа энэ баримтлал, үзэл санаа нь Монголын байлдан дагуулагчдад ноёрхлоо хэдэн зуун жилийн турш хадгалах бололцоог олгосон билээ”³⁴ хэмээн 1983 онд хэвлэсэн номондоо үнэлсэн байдаг.

Америкийн эрдэмтэн M. Rossabi Чингис хааны гүйцэтгэсэн үүргийг тодорхойлон “Чингис хаан цэргийн суут жанжин, улс төрийн гайхамшигтай арга ухаантан байсан нь эргэлзээгүй. Тэрбээр монгол аймгуудыг хөгжил хөдөлгөөнд оруулав. Түүний тугийн дор аймаг угсаатнаа нэгтгэх, дараа нь соёл иргэншлийн төлөө тэмцэх хөдөлгөөн өрнүүлэхэд монгол үндэстэн, цэргийн хүч чадлын өсөлт тусалсан байна”³⁵ гэж 1988 онд бичсэн “Хубилай хаан” зохиолдоо үнэлсэн байдаг. Эдгээрээс аваад үзэхэд Чингис хаан, Монголын эзэнт гүрний судалгаа өрнөдийн судлаачдын анхаарлыг олон жилийн турш татсаар ирсэн ба энэ нь тэр үеийн Зөвлөлтийн түүх судлаачдын үзэл баримтлалаас эрс ялгаатай байв.

БНХАУ-д Чингис хааны талаарх сурвалж материал асар их байдаг боловч энэ талаархи судалгааны ажил нилээд хожуу эхэлсэн. 1949 оноос хойш 1960-аад оны эхэн

³³ Ch. J. Halperin. *Russia and Mongol's Empire – Asian studies Journal*. №1. vol. 43, Harvard Univ. 1983, p. 239-261 (*Russia under the Tatar's yoke-Golden Horda*)

³⁴ P. Ratehnevsky. *Ginggis khan Sean Leben und wirkin*. Wiesbeden 1983

³⁵ M. Rossabi. *Khubilai Khan. His life and times*. University of California press. Berkeley, Los Angeles, London 1988. p. 4

хүртэл Хятадын нийгмийн шинжлэх ухаан марксист онолд тулгуурлан хөгжих болсон үеэс Чингис хааны талаарх судалгаа үндсэндээ хаагдсан гэж хэлж болно. Энэ үед Чингисийн талаар судалгааны 2 ном хэвлэгдэн гарсан хэдий ч хойшид энэ талын судалгаа бас бүрмөсөн хаагдсан. Чингис болон түүний үе залгамжлагчдын түүхэнд гүйцэтгэсэн үүргийг Зөвлөлтийн эрдэмтдийн үзэл баримтлалаар тодорхойлох болж ангич, намч байр сууринаас хандах болсон. Хэдийгээр Чингисийн талаар тусгайлан судалсан ном, өгүүлэл, гараагүй боловч Чингисийн түүхэнд гүйцэтгэсэн үүргийг сөргөөр үнэлж Монголын түүх, Хятадын түүхийн холбогдолтой ном сурах бичгүүдэд тусгасан байдаг.

1960 оны эхнээс байдал өөрөөр эргэж Хятадын төрийн төв хэвлэл болох “Жэньминь жибао”, “Гуанмин жибао”³⁶ сонинуудад болон эрдэм шинжилгээ судалгааны “Түүхийн судлал”, “Дэлхийн түүх”, “Түүх заах арга” зэрэг дорвитой сэтгүүлүүдэд Чингис болон түүний түүхэнд гүйцэтгэсэн үүргийг өөрөөр үнэлэх тухай өгүүллүүд хэвлэгдэн гарч эхэлсэн. Монголын хаадын байлдан дагуулал, бусад оронд ноёрхлоо тогтоосныг магтан бичиж, зөвтгөн үзсэн өгүүллүүд удаа дараа нийтлэгдэх болов. Энэ компанит ажилд Хятадын томоохон эрдэмтэн судлаачид тухайлбал, Хань Жулинь, Лю Данянь, Чжоу Гучэн, Чжоу Лянсяо, Ян Чжицзю нар татагдан орсон байдаг. Чжоу Гучэн 1961 онд “Түүхийн судлал” сэтгүүлд “Дэлхийн түүхийг хөгжүүлсэн нөхцөл байдлын тухай” өгүүлэл, Хятадын нэрт түүхч Хань Жулинь 1962 онд мөн сэтгүүлд “Чингис хааны тухай өгүүлэх нь” өгүүлэл, Чжоу Лянсяо 1962 онд мөн сэтгүүлд “Чингис хааны тухай”, Ян Чжицзю “Түүх заах арга” сэтгүүлд 1962 онд “Чингис хааны түүхэнд эзлэх үүрэг ролийн тухай” өгүүллүүдээ хэвлэн нийтлүүлсэн байдаг.³⁷ Эдгээр өгүүллүүдэд Чингис хаан, Хубилай хааны түүхэнд гүйцэтгэсэн үүрэг ролийг өөрөөр үнэлэн бичихийг уриалахдаа “Чингисийн байгуулсан их гүрэн Хятадын түүхэнд дэвшилтэт үүрэг гүйцэтгэсэн юм... Чингис хаан үндэстнүүдийн хоорондын хил хязгаарыг цуцлаж, аугаа их олон үндэстний улсыг байгуулсан. Хубилай хаан манай олон үндэстний улсыг байгуулан хөгжүүлэхэд үлэмж их гавьяа байгуулсан хүн” хэмээн бичсэн байдаг.

Төдөлгүй Хятад оронд Хань биш үндэстнүүдийг судлах асуудлаар эрдэм шинжилгээний хурал зохион байгуулагдаж, “Хятадад ганцхан Хань үндэстэн байдаг,

³⁶ “Жэньминь жибао”, 1961.VIII.10

“Гуанмин жибао”, 1962.I.21

³⁷ Чжоу Гучэн. *Lun shijie lishi fazhan de xinshi*. “*Lishi yanjiu*”, 1961 №2

Хань Жулинь. *Lun Chenzisi han*. “*Lishi yanjiu*”, 1962

Чжоу Лянсяо. *Guanyu Chenzisi han*. “*Lishi yanjiu*”, 1962 №4

Ян Чжицзю. *Guanyu Chenzisi han*... “*Lishi jiaoxue*”, 1962 №2

бусад үндэстэн бол түүний салаа мөчир”³⁸ хэмээх үзэл баримтлалаар түүхэнд хандах болж “Хятадын олон үндэстний эв нэгдэл хэзээ ч салшгүй мөнх” хэмээх номлолыг тунхагласан юм. Энэ үеэс хойш монголчууд Хятад орныг эзлэн захирч байсныг “нэгдмэл хятадын олон үндэстэн ээлжлэн өөрсдийн ноёрхлоо тогтоож төр барьж байсны жишээ. Тэд бол харийн түрэмгийлэгчид биш”³⁹ гэж үзэх болсон юм.

БНХАУ-д өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлого хэрэгжиж эхэлсэн үеэс монгол судлалын олон нийгэмлэг байгуулагдаж Хятад дахь монгол судлал хөгжлийнхөө эрчийг авч эхэлсэн. 1979 оны 8-н сард Өвөрмонголын өөртөө засах орны нийслэл Хөх хотод “Монголын түүхийг судлах бүх Хятадын нийгэмлэг”, 1979 оны 10-н сард Шинжаан-Уйгарын өөртөө засах орны нийслэл Үрэмч хотод “Монгол хэл судлах бүх Хятадын нийгэмлэг”, 1980 оны 10-н сард Нанжин хотод “Юань улсын түүх судлах нийгэмлэг”, 1987 онд Өвөрмонголын Их зуу аймагт “Чингис судлалын нийгэмлэг”, 1989 онд Шинжаан-Уйгарын өөртөө засах оронд “Ойрадын түүх судлах нийгэмлэг” тус тус албан ёсоор байгуулагдсан.

Монгол судлалаар бүх Хятадын хэмжээний эрдэм шинжилгээний бага хурал удаа дараа зохион байгуулагдаж, судалгааны ажлыг эрчимжүүлснээр 1970 оны сүүлээс Монголын түүхийн судлалаар биеэ даасан олон ном зохиол хэвлэгдэн гарах болсон. БНХАУ-д Монголын түүхийг нэгтгэн бичсэн ном “Соёлын хувьсгал”-ын дараа анх 1977 онд “Монгол үндэстний товч түүх”⁴⁰ нэртэй Өвөр Монголд хэвлэгдсэн гарсан. Энэ ном 1959 онд Юй Баяны “Өвөр Монголын түүхийн найруулал”⁴¹ ном хэвлэгдэн гарснаас хойш 18 жилийн дараа Монголын түүхийг нэгтгэн бичсэн анхны ном байв. Энэ номонд XIII-XIY зууны Монголын түүх, Чингис болон түүний үе залгамжлагчдын үйл ажиллагааг авч үзэхдээ ангич, намч, байр сууринаас үнэлэх оролдлого хийсэн байдаг. Номын эхний хуудсанд Мао Зэдуны үндэсний цөөнхийн түүхийн асуудалд хэрхэн хандах үзэл баримтлалыг “Хятад бол олон үндэстний эв нэгдлийг хангасан, хамгийн олон хүнтэй улс. Улс орны эв нэгдэл, хүн амын эв нэгдэл, олон үндэстний эв нэгдэл бол бидний үйл хэрэг баттай ялах үндсэн баталгаа мөн. Ангийн тэмцэл бол нэг ангийн ялалт, нөгөө ангийн ялагдал. Энэ бол бодит түүх, олон мянган жилийн соёл иргэншлийн түүх. Энэ үзэл баримтлалаар /ангийн тэмцлийн үзэл баримтлалаар Н.А/ түүхэнд хандвал түүхэн материализмыг бий болгоно, эс тэгвээс түүхэн идеализм дээр зогсоно. Ард түмэн олон

³⁸ “Гуанмин жибао”, 1978. III.26

³⁹ Лю Данянь. *Lun Kanxi /Канши хааны тухай/* “Lishi yanjiu”, 1961 №3

⁴⁰ Mengguzi jianshi. /Монгол үндэстний товч түүх/, Өвөр Монголын ардын хэвлэлийн газар, 1977

⁴¹ Юй Баян. *Neimenggu lishi gaiyao /Өвөр монголын түүхийн найруулал/*, Шанхай, 1959

түмэн болж байж дэлхийн түүхийг хөдөлгөгч хүчин нь болдог. Үндэсний тэмцэл эцсийн эцэст ангийн тэмцлийн асуудал” хэмээсэн үгийг удиртгал болгон бичсэн байдаг. Хэдийгээр энэ ном марксист онолд тулгуурлан түүхэн үйл явдалд үнэлгээ өгөхийг хичээсэн боловч 60-аад оноос өмнө Монголын түүхэнд хандаж байсан үзэл баримтлалаас нилээд өөр үзэл баримтлалаар бичигдэн хэвдэгдсэн. Чингис хааныг “боолын нийгмийн язгууртны гаралтай” гэж бичээд Чингисийг хувь хүнийх нь хувьд, түүний үйл ажиллагаанд нэлээд тодорхой үнэлэлт өгсөн байдаг. Чингис хааныг хувь хүнийх нь хувьд үнэлэхдээ түүхэн үйл явцын баримтад тулгуурлан “хүнд тусархаг ханддаг хүнлэг чанарыг нь үнэлэн /yi ren yi zi yi, chen ren yi zi ma/ түүгээрээ бусад аймгийн олон язгууртныг өөртөө татаж, дагаар оруулж, анд болгож чаддаг байв.”⁴² Мөн Чингисийн дайнч, байлдаанч болох шалтгааныг “Чингис хааныг дайнч байлдаанч болох явдалд бусад олон аймаг, улс гүрнүүд түүний элч, төлөөлөгч, хүмүүсийг тонон дээрэмдэж, алан хяддаг явдал нөлөөлсөн”⁴³ хэмээн дүгнэсэн байдаг. “Алтан улсын ноёлогч ангийнхны Монголыг эзлэх гэсэн түрэмгийллийг зогсоож, харин тэдний хоорондын харилцаа холбоонд хязгаар тогтоолгүй, маш өргөн хүрээнд эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлсэн” гэж дүгнэсэн нь Хятад Чингис хааныг өөрөөр үнэлэх үнэлгээнд тухайн үеийн Зөвлөлт, Монгол улстай харьцуулахад хамаагүй эрт орсон байв. Гэсэн хэдий ч энэ ном нь “Монгол үндэстэн эрт дээр үеэс Хятадын хойд хэсэгт оршин тогтнож ирсэн нэг гэр бүлийн дотор ахан дүүгийн найрсаг харилцаатай, үеийн үед зэрэгцэн оршиж байсан, монголчууд ба монгол үндэстэн Хятадын бүрэлдэхүүн хэсэг” хэмээх үзэл баримтлалаар бичигдсэн, Монгол үндэстэн монголчуудын талаар хятадын баримталдаг уламжлалт бодлогыг түүхэн талаас нь “нотлон” бичих оролдлого хийсэн ном байв. Энэ ном хэвлэгдсэнээс хойш БНХАУ-д Монголын түүхийн номнууд удаа дараа хэвлэгдэн гарах болсон. “Монгол үндэстний товч түүх” номыг 1979, 1986 онуудад дахин засварлан хэвлэн гаргасан байдаг. 1985 онд “Монгол үндэстний түүхийн найруулал”⁴⁴ Хөх хотод хэвлэгдэн гарсан. 1989 онд “Монгол үндэстний ерөнхий түүх”⁴⁵ гурван ботиор хэвлэгдэн гарсан. 1991 онд Бээжинд “Монгол үндэстний ерөнхий түүх”⁴⁶, 1993 онд “Монгол үндэстний ерөнхий түүх”⁴⁷ дөрвөн ботиор

⁴² Мөн тэнд, тал 14

⁴³ Мөн тэнд, тал 15

⁴⁴ Mengguzu lishi gaiyao. /Монгол үндэстний түүхийн найруулал/, Хөх хот, 1985

⁴⁵ Mengguzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх/, Хөх хот, 1989

⁴⁶ Mengguzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх/, Бээжин, 1991

⁴⁷ Mengguzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх/, Өвөрмонголын Ихзуу аймаг, 1993

Өвөрмонголын Ихзуу аймагт хэвлэгдсэн. 1995 онд Бээжинд “Монгол үндэстний ерөнхий түүх”⁴⁸ дахин засварлагдан хэвлэгдсэн.

Монголын ерөнхий түүхийг олон удаа ойр ойрхон засварлан хэвлэж байгаа нь Монголын түүхийн судалгаанд чанарын өөрчлөлт гаргах, засаж залруулан бичих шаардлага байгааг харуулж байна. Монголын түүхийн судалгаа нь Хятадын хувьд үндэстний цөөнхийн түүх судлалын асуудал руу ордог учир түүнийг хэрхэн авч үзэх тал дээр улсын бодлого боловсруулах, түүнийхээ дагуу Монголын түүхийг авч үзэх, төрийн бодлогод нийцүүлэн бичих болж байгаагаараа онцлогтой юм.

Нөгөө талаас Хятадын нийгмийн шинжлэх ухаан нь өдгөөг хүртэл марксист-ленинист, маозэдуны онол үзэл баримтлалаас салаагүй, түүнийг мөрдөх, баримтлах шаардлагатай байгаатай холбоотой юм. Мөн Монголын түүхийг Хятадын түүхийн хавсарга болгох зорилгоор судлаж бичсэн нь элбэг байдаг. Хэдий тийм боловч “Юань улсыг судлах нийгэмлэг”, “Чингис судлалын нийгэмлэг” байгуулагдсанаас хойш үзэл суртал, бодлогын хүрээнд гэхээсээ илүү эрдэм шинжилгээ, практик судалгаа руу орсон олон ном хэвлэл хэвлэгдэн гарах болсон юм. Тухайлбал 1980 онд Нанжингийн их сургуулийн түүхийн факультетын Юань гүрний түүх судлалын тэнхмээс Мэн Симиний “Юань гүрний нийгмийн ангийн бүтэц”⁴⁹, 1982 онд Нанжин хотод “Юань гүрний түүх ба хойд зүгийн үндэстнүүдийн түүхийн судалгааны сэтгүүл”⁵⁰ хэвлэгдсэн, 1984 онд Бээжинд “Юань гүрний түүхийн судалгааны эмхтгэл”⁵¹, 1985 онд Бээжинд Нуан Шицянь “Юань гүрний түүхийн домог”⁵², 1985 онд Ли Ган Уханьд “Юанийн үеийн нийгэм эдийн засгийн түүхийг судлах нь”⁵³, 1986 онд нэрт түүхч Хань Жулиний “Юань улсын түүх”⁵⁴, 1991 онд Чен Гаохуа “Юань улсын түүхийн судалгаа”⁵⁵, 1992 онд Ли Чжиань Тянжиньд “Юанийн үеийн засаг захиргааны хуваарилалтын системийг судлах нь”⁵⁶, 1992 онд Ху Чжаоси “Сун ба Монголын Юань гүрний харилцааны түүх”⁵⁷ гэх зэрэг олон судалгааны ном зохиол, өгүүлэл хэвлэгдсэн байна. Эдгээрт Юань гүрний үед Хятадын нийгэмд гарсан өөрчлөлт, монголчуудын Хятадын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ролийг тодорхойлохыг зорьсон байна.

⁴⁸ Mengguzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх/, Бээжин, 1995

⁴⁹ Юань гүрний нийгмийн ангийн бүтэц. Нанжин, 1980

⁵⁰ Юань гүрний түүх ба хойд зүгийн үндэстнүүдийн түүхийн судалгааны сэтгүүл, Нанжин 1982

⁵¹ Юань гүрний түүхийн судалгааны эмхтгэл. Бээжин, 1984

⁵² Нуан Шицянь, Юань гүрний түүхийн домог. Бээжин, 1985

⁵³ Ли Ган, Юанийн үеийн нийгэм эдийн засгийн түүхийг судлах нь, Ухань. 1985

⁵⁴ Хань Жулин, Юань улсын түүх. Бээжин, 1986

⁵⁵ Чен Гаохуа, Юань улсын түүхийн судалгаа. Бээжин, 1991

⁵⁶ Ли Чжиань, Юанийн үеийн засаг захиргааны хуваарилалтын системийг судлах нь, 1992

⁵⁷ Ху Чжаоси, Сун ба Монголын Юань гүрний харилцааны түүх. Чэнду, 1992

Чингис хаан түүний үйл ажиллагааг тусгайлан судалсан номууд хэвлэгдэн гарсан. 1987 онд Хөх хотод Сайшаалын “Чингис хааны товчоон”, 1989 онд Хөх хотод Чжан Чжаньхуа, Баяндорж нарын “Чингис хааны цэргийн стратегийн үндсэн мэдэгдэхүүн”⁵⁸, 1990 онд Далантайн бичсэн “Монголын цэргийн эрдмийн нууц ба Чингисийн цэргийн стратегийн судалгаа”⁵⁹ зэрэг тодорхой, нарийвчилсан судалгааны номууд олноор хэвлэгдэн гарсаар байна. Чингис хаан судлалд өвөр монголчууд идэвхтэй оролцож олон ном зохиол тууриваж байгаа нь Хятадын түүх судлалд гарч буй нэг дэвшил гэж үзэж болно. Тэдгээрийн монгол хэл дээр бичигдсэн ном нь ханз үсгээр буухдаа зарчмын ялгаатай байдгийг ч тэмдэглэхэд илүүдэхгүй байх. Монголчуудын бичсэн зохиолд Чингис хааныг хэт магтан дуулах, XIII-XIV зууны Монголын байлдан дагууллын түүхийг өрөөсгөл, өөрөөр хэлбэл зөвхөн эерэг талаас нь дөвийлгөн бичих оролдлого байгааг үгүйсгэх аргагүй. Энэ үзэгдэл манайд ч газар авах хандлагатай байгааг тэмдэглэмээр байна. Чингис хаан, түүний байгуулсан Их гүрний түүхийг Хятадад судлахдаа монголчуудын байгуулсан Их гүрэн Хятадын түүхийн нэгэн хэсэг, монголчууд Хятадын цөөнх үндэстэн учир Хятадын түүхэнд цөөнх үндэстэн ээлжлэн төр барьж байсны нэг илрэл гэсэн үзэл баримтлалыг Монголын түүхээр бичигдсэн ихэнх номуудад тусгасан байдаг. Сүүлийн үед энэ үзэл баримтлалд бас зарчмын өөрчлөлт орж ирж байна.

2002 онд Өвөр Монголын Их сургуулиас хэвлэн гаргасан “Монгол үндэстний ерөнхий түүх”⁶⁰ номны 1-рт “Чингис хаан Монголын олон аймгийг нэгтгэснээр Монгол нутагт улс төр, эдийн засаг, соёлын дэвшил хөгжлийг авч ирсэн. Монгол үндэстний хөгжил Хятадын үндэстнүүдийн хөгжлийн нэг чухал хэсэг юм. Олон үндэстнүүдийг нэгтгэсэн нь улсын /хятад Н.А/ түүхэнд чухал нөлөө үзүүлсэн, дэлхийн түүхийг ч агуулгаар нь баяжуулсан”⁶¹ гэж үзсэн байна. Харин нэг ялгаатай нь тус ном анх удаа Чингис хаан 1206 онд Монгол олон аймгийг нэгтгэж “Их Монгол улс байгуулагдсан” /da menggu guo/ гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Гэхдээ уг номонд “Da menggu guo- Их Монгол улс гэдэг нь “үнэн хэрэгтээ нэг үндэстний нэрээр улсаа цоллосон” хэрэг гэж үзсэн байгаа. Анх удаа Хятадад хэвлэгдсэн Монголын түүхийн номонд “Монголын хаант улс” /Menggu hanguo/ гэдэг нэрийг оруулснаа зохиогчид цохон тэмдэглэсэн байна.⁶²

⁵⁸ Чжан Чжаньхуа, Баяндорж. Чингис хааны цэргийн стратегийн үндсэн мэдэгдэхүүн. Хөх хот. 1989

⁵⁹ Далантай. Монголын цэргийн эрдмийн нууц ба Чингисийн цэргийн стратегийн судалгаа. Хөх хот. 1990

⁶⁰ Menggu minzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх /, Өвөр Монголын Их сургуулийн хэвлэл, 2002

⁶¹ Menggu minzu tongshi /Монгол үндэстний ерөнхий түүх /, Өвөр Монголын Их сургуулийн хэвлэл, 2002, 1-р дэвтэр, т. 138-139

⁶² Мөн тэнд, 2002, 2-р дэвтэр, т. 1

2005 онд Бээжинд хэвлэгдсэн өргөн олон нийтэд мөн гадаадын уншигчдад зориулагдан бичигдсэн “Хурдан уншигдах Хятадын түүх”⁶³ номонд XIII-XIV зууны Монголын түүх, Чингисийн түүхийг “Дэлхийн Хятад” хэмээх бүлэгт хамруулан бичсэн байна. Уг номонд “Монгол үндэстэн Чингис хааны удирдлаган дор... улсын /хятад Н.А/ газрын зургийг Ази, Европ хоёр тивээр өргөжүүлэн тэлж, дэлхийн эзэнт гүрнийг байгуулсан”⁶⁴ гэсэн дүгнэлт хийсэн нь наяд, ерээд оны “Чингис хаан Хятадын олон үндэстнийг нэгтгэж, Хятадын түүхэнд гарамгай гавьяа байгуулсан” хэмээх үзэл баримтлалаас зарчмын ялгаатай дүгнэлт болсон байна. Мөн “Монгол, Хятадын хойд хэсгийг нэгтгэж, хойт зүгт хүчирхэг улсыг байгуулсан. Хятадын цэргийн хэрэг, техникт дэвшил гарч, галт зэвсэг дэлгэрсэн, Монголын цэрэг бол тухайн үедээ дэлхийд хамгийн хүчирхэг цэрэг байсан”⁶⁵ гэж дүгнэн бичсэн байна.

Хэдийгээр БНХАУ-д монгол судлал эрчимтэй хөгжиж байгаа ч төрийн бодлого, үзэл баримтлалын дагуух хайрцганд оруулж, “нотолгоо” хийх оролдлого явагдсаар байна. Хятадын өвөр монгол эрдэмтэн, Тайваньд амьдарч байгаа Го Гуаньянь, монгол нэр нь Нагусайнхүү “Орчин үеийн эх газрын Хятадын монгол судлалын талаарх бүтээлийн эмхтгэл. XX зууны сүүл үеийн Хятадын монгол судлалыг эргэн харах нь”⁶⁶ номондоо: “Бид олон улсын монгол судлалын ажилд анхаарлаа хандуулж... бодит шинжлэх ухаан, судалгааны уур амьсгалаар амьсгалж, монгол судлалын ажлын түвшинг илүү өндөр түвшинд гаргаж, шинэ хувь нэмэр оруулах хэрэгтэй байна”⁶⁷ гэж дүгнэж хэлсэн байдаг. БНХАУ Чингис судлалд асар их ач холбогдол өгч биеэ даасан Чингис судлал, Юань улсын судалгааны хүрээлэнгүүд байгуулж, Чингис судлалаар олон ном зохиол хэвлэн гаргаж, ӨМӨЗО-ны Чингисийн онгонд асар их хөрөнгө зарцуулж байгаа нь санамсаргүй хэрэг огтхон ч биш юм. Хятад өөрийн үзэл баримтлалаа баталгаажуулах ажилд их анхаарч байгаагийн илрэл юм.

Эцэст нь дүгнэж хэлэхэд Чингис хааны талаарх судалгааны ажилд дэлхийн эрдэмтэд XVIII зуунаас эхлэн анхаарлаа хандуулж судалж ирсэн байна. Үүнд Орос орон геополитикийн сонирхлын үүднээс Петр I хааны үеэс төрийн хэмжээнд анхаарч ирсэн бөгөөд Оросын эрдэмтэд “Монголын нууц товчоог” нээн илрүүлэхээс эхлээд Чингис

⁶³ Zhongguo lishi sudu / Fast reading of Chinese history/, Бээжин, 2005

⁶⁴ Мөн тэнд, тал 177

⁶⁵ Мөн тэнд, тал 178

⁶⁶ Dandai zhongguo dalu mengguxue yanjiu gailun. Ershi shijimo zhongguo mengguxue yanjiu huimou /Орчин үеийн эх газрын хятадын монгол судлалын талаархи бүтээлийн эмхтгэл. XX зууны сүүл үеийн хятадын монгол судлалыг эргэн харах нь/ Тайвань, Монгол-Төвдийн хорооны хэвлэл, 1999

⁶⁷ Мөн тэнд, т.5

хааны үнэлгээний талаар шинжлэх ухаанд бодит хувь нэмэр оруулсан олон бүтээл тууригласан. Гэвч Орос оронд Чингис хаан, түүний үе залгамжлагчдын талаарх эрдэмтдийн судалгааны үнэлгээ, төрийн үзэл баримтлалтай байнга харшилдаж ирсэн бөгөөд одоог хүртэл нэгдсэн “дүгнэлтэнд” хүрээгүй байна. Өрнөдийн орнуудад Чингис хаан болон Монголын эзэнт гүрний судалгаа төрийн бодлогын хүрээнд гэхээсээ хувь хүмүүсийн сонирхлын хүрээнд илүү хийгдэж эхэлсэн байна. Газарзүйн алслал, дорнодахин судлалд харьцангуй хожуу орсон зэрэг хүчин зүйлээс шалтгаалан олон оронд энд тэнд цөөн тооны эрдэмтэд судалгаа хийж эхэлсэн ч судалгааны хөгжлийн явц тасраагүй, харин ч “социалист” орнуудад хэвлэхийг хориглосон бүтээлүүдийг хэвлэн нийтэлж олны хүртээл болгож байсан байна. Хүйтэн дайны үед ч судлаачид Чингис хааны талаарх судалгааны ажлаа үргэлжлүүлэн хийж байсан бөгөөд олон жилийн судалгааны үр дүнд ХХI зуунд Чингис хааныг мянганы хүнээр тодруулаад байна.

Хятадын хувьд авч үзвэл БНХАУ-ын нийгмийн шинжлэх ухаан “социалист замаар” хөгжсөөр байна. Чингис хааны үнэлгээний асуудалд ангич, намч үүднээс хандаж үнэлэх явдал ч байсаар байна, тодорхой хугацаанд энэ талын судалгаа бүрмөсөн хаагдсан үе ч бий, 70 оны сүүлчээс Чингис хаанд өгөх үнэлгээнд эергээр хандаж, Хятадын болон дэлхийн түүхэнд гүйцэтгэсэн үүрэг ролийг төрийн бодлогын хүрээнд авч үзэж, Чингис хааны талаарх Хятадын төрийн үзэл баримтлал болох “Чингис хаан Хятадын цөөнх үндэстэн монголчуудын төлөөлөгч, түүний байгуулсан Эзэнт гүрэн Хятадын гүрэн” гэсэн үзэл баримтлалыг “нотлох” зорилготой асар их ажил хийж, хөрөнгө гаргаж байна. Иймээс олон орны эрдэмтдийн судалгаа, үзэл баримтлалыг ялган салгаж, харьцуулан дүгнэж, дэнслэн бодож, өөрсдөө дэлхийн хэмжээний судалгаа хийдэг чадварыг эзэмшиж, Монгол улс оршин тогтнохын шинжлэх ухааны үндэслэл болсон агуу түүхэндээ эзний хувиар хандан судлах ажлыг эрчимжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд олон орны эрдэмтдийн олон зуун жилийн бүтээл тууригвал, хүч хөлөлмөр, мэдлэг чадвар, хамгийн гол нь шинжлэх ухааны судалгаа, нотолгоо дэм болох нь дамжиггүй.